



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/47

Сүхбаатар сум

“Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцгаая” аяныг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө, болзолт уралдааны удирдамжийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2, 2.1.7, 2.5.3, 2.5.4, 2.5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцгаая” аяныг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг нэгдүгээр, аяны болзолт уралдааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Нэгдсэн төлөвлөгөө, уралдааны удирдамжийг аймгийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөн туслах, аяны нэгдсэн үр дүнг тайлагнахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ч.Жаргалсайхан) -д үүрэг болгосугай.

3.Сургууль, цэцэрлэгийн удирдлага, багш, эцэг эх асран хамгаалагч, хүүхдүүдэд зориулсан сургалт, сурталчилгаа, нөлөөлөл, мэдээ мэдээллийг түгээх арга хэмжээг удирдан зохион байгуулж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга (П.Оюун)-д даалгасугай.

4.Зардалд шаардагдах 7,000,000 (долоон сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (О.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.

5.Энэ захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ажлын хэсгийн дарга (Ө.Сувдаа)-д даалгасугай.



Н. БАТВАДОРЖ


Боловсруулсан:

Хянасан:

Хувь:

21 804 877.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 09 -ны өдрийн А/47
тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



“Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцаага аян”-г
хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө

МНӨА 00005 9055053

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хамрах хүрээ | Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан | | Төсөв | Хүрэх үр дүн |
|--|---|------------------------|---------------------------------------|---|---|--------------------|--|
| | | | | Үндсэн | Хамтран | | |
| Нэг. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд: | | | | | | | |
| 1 | “Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцаага” аяны нээлтийн ажиллагааг аймаг дээр зохион байгуулах | 2021-11-25 | Сумдын ЗДТГ-ын дарга нар, | АЗДТГ-ын НБХ | УБ хотын Эерэг өөрчлөлтийн түүчээ” ТББ | АЗД-ын нөөц сан | Нээлтийн үйл ажиллагаанд 200 иргэнийг хамруулж мэдээлэл хүргэнэ. |
| 2 | Аяны хүрээнд аймгийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, баталгаажуулан сумд, хэлтэс, агентлагуудад хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллах | 2022-01-19 | 17 сум, 6 тосгон, албан байгууллагууд | АЗДТГ-ын НБХ | Ажлын хэсэг, БШУГ, ГБХЗГ | - | Төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна. |
| 3 | “Дэлгэцийн донтолтоос сэргийлж, эрүүл мэндээ хамгаалцаага-аян” нээлтийн ажиллагааг байгууллага дээрээ зохион байгуулах | 2022-02-09 | Хүүхэд, эцэг эх, олон нийт | ЕБС, цэцэрлэг | АЗДТГ, УБ хотын Эерэг өөрчлөлтийн түүчээ” ТББ | Байгууллагын төсөв | Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлж, зөв дадал хэвшилд суралцаж, амьд харилцааг эрхэмлэнэ. |
| 4 | Ерөнхий боловсролын 35 сургууль, 44 цэцэрлэгийн хүүхдүүдээс “Дэлгэцийн донтолт”-ыг илрүүлэх | 11-р сарын 19-ны дотор | Хүүхэд, эцэг эх | АЗДТГ-ын НБХ | ЕБС, цэцэрлэгийн захиргаа | - | Хүүхдийн донтолтын эрсдэлийн |



| | | | | | | | |
|---|--|----------|-----------------|-------------|-------------|---------------------------------|--|
| | судалгааг авч нэгтгэх, дүн шинжилгээ хийж, удирдлагад танилцуулан шийдвэр батлуулах | | | | | | үнэлгээг гаргаж эцэг эхчүүдэд зөвлөгөө, зөвлөмж хургуулна. |
| 5 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдээс "Дэлгэцийн донтолт"-ыг илрүүлэх давтан судалгааг авч нэгтгэх, дүн шинжилгээ хийх | 05-р сар | Хүүхэд, эцэг эх | БШУГ | ГБХЗГ | - | ХШУ-хийж шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ. |
| 6 | Аяны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан хамгаалалт, урамшуулах, хариуцлага тооцох | 05-р сар | Хүүхэд, эцэг эх | БШУГ, ГБХЗГ | Ажлын хэсэг | АЗД-ын нөөц сан, хандив тусламж | Үр дүнгээ үнэлнэ. |

Хоёр:Эмчийн оношилгоо, зөвлөгөө өгөх ажлын хүрээнд

| | | | | | | | |
|---|--|----------------|---------------------------|---------------|------------------|-----------------|---|
| 1 | Сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийг нүд, мэдрэл, сэтгэцийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | 02-р сар | Хүүхэд, эцэг эх | ЕБС, цэцэрлэг | ЭМГ Сумдын ЗДТГ, | АЗД-ын нөөц сан | Онош тодруулж эрүүлжүүлэх ажил хийгдэнэ. |
| 2 | Өсвөр насны хүүхдүүдэд дэлгэцийн донтолтоос урьдчилсан сэргийлэх сэтгэл зүйчийн зөвлөгөө өгөх | 01, 02, 03 сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | ДЭМОУ | БШУГ, ГБХЗГ | 4000\$ | Нэн хэрэгцээт кейс дээр мэргэжлийн хүмүүст холбон зуучлах |

Гурав:Сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

| | | | | | | | |
|---|---|-------------------------|-----------------|--------------|--|-----------------|---------------------------------------|
| 1 | Бага насны хүүхдийг дэлгэцийн донтолтоос сэргийлэх "Дэлгэцээс холдуулах дадлууд" хүүхдийн ном хэвлэх, гарын авлагыг боловсруулан, хянуулж, 1000 ширхэгийг хэвлүүлэх | 11-р сарын 19-ны дотор | Хүүхэд, эцэг эх | АЗДТГ-ын НБХ | УБ хотын Эераг өөрчлөлтийн түүчээ" ТББ | АЗД-ын нөөц сан | Хүүхэд эцэг эхэд мэдлэг дадал олгоно. |
| 2 | Бага насны хүүхдийг дэлгэцийн донтолтоос сэргийлэх "Дэлгэцээс холдуулах дадлууд" 1000 гарын авлагыг сургууль, цэцэрлэгүүдэд түгээх, таниулах ажлыг зохион байгуулах | 02-р сарын 11-ний дотор | Хүүхэд, эцэг эх | БШУГ | ЕБС, цэцэрлэгийн захиргаа | - | Хүүхэд эцэг эхэд мэдлэг дадал олгоно. |



| | | | | | | | |
|---|---|-------------------------|---------------------------|------------|---|-------------------------|---|
| 3 | Сургууль, цэцэрлэгийн эмч нарын дунд хүүхдийн дэлгэцийн зөв зохиистой хэрэглээний талаар цахим сургалт зохион байгуулах | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | БШУГ | ДЗМОУ, УБ хотын Зэрэг өөрчлөлтийн түүчээ" ТББ | Төслийн газрын зардлаас | Мэдлэг хандлагад ахиц гарна. |
| 4 | Цахим орчинд бага насны хүүхдийн ажиллах зөвлөмж боловсруулах, түгээх | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | ЭМГ АНЭ | ГБХЗГ | - | Мэдлэг хандлагад ахиц гарна. |
| 5 | Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх сургагч багш бэлтгэх | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | ЭМГ АНЭ | ГБХЗГ, БШУГ | - | Иргэд, олон нийтэд сургагч багш нараар дамжуулан мэдлэг олгоно. |
| 6 | "Z үеийнхэн ба цахим технологийн эрин үе" цахим хэлэлцүүлэг зохион байгуулах | 02-05-р сар | Хүүхэд, эцэг эх | БШУГ | ГБХЗГ | - | Цахим хэрэглээний талаар мэдлэг олгоно |
| 7 | Хүүхэд хамгааллын сургалтыг зохион байгуулах | 01, 02,03, 04, 05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | ДЗМОУ | ГБХЗГ, БШУГ, ЦГ | 1400\$ | Хүн бүр хүүхэд хамгааллын мэдлэгтэй болно. |
| 8 | Хүүхэд хамгаалалд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах | 06-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | ДЗМОУ | ГБХЗГ, БШУГ, ЦГ | 1000\$ | Хүчирхийллээс ангид хүмүүжлийн зэрэг аргад суралцана. |
| 9 | Цахим залигчийн гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | 02-05-р сар | Хүүхэд | ЦГ | ГБХЗГ, БШУГ, ЦГ | - | Цахим залигчаас өөрийгөө хамгаалах аргад суралцана. |
| Дөрөв: Гэр бүлд зориулсан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд | | | | | | | |
| 1 | "Гэр бүлийн утасгүй цаг" арга хэмжээг зохион байгуулах | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | ГБХЗГ, | БШУГ, Сумдын ЗДТГ | - | Гэр бүл дэх халуун дулаан харилцаа нэмэгдэнэ. |
| 2 | Эцэг эхчүүдэд "Гар утас хүүхэд аргадах тоглоом биш" гэдгийг сануулах видео бичлэг, зөвлөмж, | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | ГБХЗГ, ЭМГ | УБ хотын Зэрэг өөрчлөлтийн | - | Эцэг эх, асран хамгаалагч нарт мэдлэг олгоно. |



| | брошур хийж түгээх | | | | | түүчээ" ТББ, БШУГ | | |
|--|---|-------------|---------------------------------|---------------------------------|--|-------------------------------|--|--|
| 3 | Нэг цагт 5 мин утаснаасаа татгалзая" чөлэнж | | Хүүхэд, эцэг эх | ГБХЗГ, УЗХороо | БШУГ, Сумдын ЗДТГ | - | Эцэг эх, асран хамгаалагч нар, хүүхэд багачуудыг уриалга, чөлэнжид нэгдүүлж эерэг хандлагыг түгээнэ. | |
| 4 | Гэр бүлийн дүрэм боловсруулах, уриалга гаргах, нэгдэхийг эцэг эхчдүүдэд уриалах | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | ГБХЗГ, УЗХороо | БШУГ, Сумдын ЗДТГ | - | Мэдлэг хандлагад ахиц гарна. | |
| 5 | Эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн дэлгэцийн зөв зохистой хэрэглээний талаар цахим сургалт зохион байгуулах | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | ГБХЗГ | ДЭМОУ, УБ хотын Эерэг өөрчлөлтийн түүчээ" ТББ | Төслийн газрын зардлаас | | |
| Тав: Салбар хоорондын уялдааг хангах ажлын хүрээнд: | | | | | | | | |
| 1 | Тайз дэлгэцийн богино хэмжээний зохиомжийг хийж, түгээх | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | "Сэлэнгийн Долгио" чуулга | БШУГ, Сумдын ЗДТГ | - | Дэлгэцийн донтолтын хор уршиг, сэргийлэх аргын мэдлэг олгоно. | |
| 2 | "Дэлгэцийн донтолт ба Гэр бүлийн анхаарал" сэдэвт жүжигчилсэн тоглолтыг зохион байгуулах | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх | "Сэлэнгийн Долгио" чуулга | БШУГ, Сумдын ЗДТГ | - | Хүүхдийндуухоо лойг сонсож шийдвэр гаргагчид танилцуулна. | |
| 3 | Хүүхдийн дуу хоолой сонсох "Хүүхдээ сонсье" формыг зохион байгуулах | 01-05-р сар | Хүүхэд | ДЭМОУБ | ГБХЗГ, БШУГ, Сумдын ЗДТГ | 2317\$ | Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлж, зөв дадал хэвшилд суралцаж, амьд харилцааг эрхэмлэнэ. | |
| 4 | Донтолтын талаар сонирхолтой сэдвээр мэтгэлцээн зохион байгуулах | 03-р сар | Хүүхэд, эцэг эх, багш | ГБХЗГ, | БШУГ, ЦГ, ЭМГ, УЗХороо | - | | |
| 5 | Мэдээллийн явууллын самбар аялуулах | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | ЦГ, УЗХороо | ГБХЗГ, БШУГ | - | | |
| 6 | Шторк уралдаан зохион байгуулах | 02-р сар | ЕБС, цэцэрлэг | БТСГ, УЗХороо | БШУГ | - | | |



| | | | | | | | |
|---|--|-------------|---------------------------|---------------------------------------|--|------------|--|
| 7 | “Дэлгэцтэй биш, Дэлгэсэн номтой нөхөрлөө” цуврал номын сангийн үйлчилгээтэй хамтран зохион байгуулах | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | АННомын сан, | ГБХЗГ, БШУГ | 691000 төг | Иргэд олон нийт, хүүхэд багачуудыг амралт чөлөөт номтой нөхөрлүүлэх, эрүүл мэндээ хамгаална. |
| Зургаа:Гадаад дотоодын сайн туршлагыг судлах ажлын хүрээнд | | | | | | | |
| 1 | “Дэлгэцийн донтолтоос сэргийлэхэд боловсролын байгууллагын үүрэг, оролцоо”-туршлага | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | БШУГ ЕБС, цэцэрлэг | Сүхбаатар сумын ЕБ-3-р сургууль | - | Багш, сурган хүмүүжүүлэгч нарын туршлагыг хуваалцана. |
| 2 | “Дэлгэцийн донтолтоос сэргийлэхэд эцэг эхийн үүрэг, оролцоо”-туршлага | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | БШУГ ЕБС, цэцэрлэг | СБ-сумын 4-р цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл | - | Туршлага, ололт амжилтыг эцэг эхчүүдэд хүргэнэ. |
| 3 | “Дэлгэцийн донтолт”-оос сэргийлж буй практик аргууд олон улсын жишээн дээр | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | БШУГ ЕБС, цэцэрлэг | Дэлгэцийн донтолт-бодит аюул” тэслийн зөвлөх Ц.Лхагвасурэн | - | Дадал хэвшилд сургаж, амьд харилцааг бий болгоно. |
| 4 | Дэлгэцийн донтолтоос сэргийлэх “Гэр бүлийн сайн жишээ”-г түгээх | 01-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | БШУГ ЕБС, цэцэрлэг | УБ хотын Эерэг өөрчлөлтийн түүчээ” ТББ, | - | Эерэг дадал хэвшилтэй гэр бүлийг бий болгоно. |
| Долоо:Мэдээ мэдээллийн ажлын хүрээнд | | | | | | | |
| 1 | Хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээнүүдийг хүүхэд багачууд, эцэг эх, иргэд олон нийтэд мэдээллийн бүх хэлбэрээр сурталчлах ажлыг зохион байгуулах | 02-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | АЗДТГ-ын ХШУХ ГБХЗГ, ЕБС, цэцэрлэг | Аймгийн ажлын хэсэг, УБ хотын Эерэг өөрчлөлтийн түүчээ” ТББ, | - | Иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж, урьдчилан сэргийлэх арга, туршлагыг түгээж |



| | | | | | | | | |
|---|--|-------------|---------------------------|----------------------|--|---|---|--------------|
| | | | | | | | | сурталчилна. |
| 2 | Мэдээллийн аялуулах явуулын самбар | 02-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | ГБХЗГ, ЕБС, цэцэрлэг | Аймгийн ажлын хэсэг, БШУГ УБ хотын Эерэг өөрчлөлтийн түүчээ" ТББ | - | Сайн туршлага, шилдэг жишээг бусад байгууллагад сурталчилна. | |
| 3 | Дэлгэцээс номын хүүхдүүдийн донтолтын уралдаан үзэсгэлэн хэвлэл сошиал хуудсуудаар /Номын даалгаврын бүтээлүүдээр анги тус бүрээс/ холдуулах агуулгыг дунд сэдвээр зарлаж, мэдээллийн хэрэгсэл, арын хуудсан дахь зураг зургаар сурталчлах | 02-05-р сар | Хүүхэд, эцэг эх, багш нар | ГБХЗГ, ЕБС, цэцэрлэг | АЗДТГ-ын ХШУХ, УБ хотын Эерэг өөрчлөлтийн түүчээ" ТББ, | - | Иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж, урьдчилан сэргийлэх арга, туршлагыг түгээж сурталчилна. | |



.